



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2016 оны 11 дүгээр
сарын 1-ний өдөр

Дугаар 87

Улаанбаатар
хот

Орон тооны бус зөвлөл шинэчлэн байгуулах тухай

1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.1-д заасан шалгуурыг бүрэн хангасан Монгол Улсад төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай:

- Дарга: -Үндэсний хөгжлийн газрын дарга
- Байнгын гишүүд: -Үндэсний хөгжил, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан Засгийн газрын референт;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга;
- Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга;
- Татварын ерөнхий газрын дэд дарга;
- Үндэсний хөгжлийн газрын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга;
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Экспортыг дэмжин хөгжүүлэх газрын дарга (тохиролцсоноор);
- Төслийн удирдлага, хөгжлийн хүрээлэнгийн захирал.
- Байнгын бус гишүүд: -Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;


-Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга.

Нарийн бичгийн дарга:

-Үндэсний хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Орон тооны бус зөвлөл байгуулах тухай” Ерөнхий сайдын 2015 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 89 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ